



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/416

Булган сум

Төсөл сонгон шалгаруулах дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны дарга: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Ч.Оюун- Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
А.Пүрэвжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Баярбат (МҮХАҮТ-ын Булган аймаг дах салбарын тэргүүлэгч гишүүн)

Т.Жаргалант (Хөдөө, аж ахуйн хоршоологчдын холбооны тэргүүн)


Ч.Отгонжаргал (Монголын Өмгөөлөгчдийн холбооны Булган аймаг дахь Салбар зөвлөлийн дарга, хуульч өмгөөлөгч)

Д.Амгалан (Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Булган салбарын гишүүн)

Нарийн бичгийн дарга: Б.Батбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Төсөл сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж, тайлагнахыг дэд хорооны дарга (Г.Давааням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ